



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ
ХУХЗЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

10/19 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 8/10

Мандалговь

Б.Гансүхийг ажилд авах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 23 дугаар зүйлийн 23.2.2, Засгийн газрын 2014 оны 322 дугаар тогтоопын 4 дүгээр хавсралт, иргэн Б.Гансүхтэй 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр бичгээр байгуулсан 2018/06 тоот Хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бямбадоржийн Гансүхийг тус газрын дэргэдэх Хүүхдийн паркийн Операторчин-жолоочийн албан тушаалд 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан, тур томилж ажиллуулсугай.

2. Б.Гансүхийн сарын үндсэн цалинг TY-3-1 шатлал, зэрэглэл, ангилалд хамруулан 402075 /Дөрвөн зуун хорин мянга далан таван/ төгрөгөөр тогтоон цалинжуулахыг няяглан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, төрийн хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэн, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг Б.Гансүхэд үүрэг болгосугай.

4. Тус газрын дэргэдэх Хүүхдийн паркийн Операторчин-жолооч Б.Гансүхэд хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, ажилд томилсон тухай тушаал тус бүрийн нэг хувийг гардуулж өгөхийг Захиргаа, хүний нөөц, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Ц.Энхбилгүүн/-д даалгасугай.

ДАРГА Ц.ГАНЗОРИГ

12 019

Tushaal-2018 docx



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГЭР БҮЛ
ХҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 5713

Мандалговь

Г Д.Чогсомжавыг ажилд авах тухай

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 23 дугаар зүйлийн 23.2.2, Засгийн газрын 2014 оны 322 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 01/104 тоот албан бичиг, Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны дүрмийн 4.2, иргэн Д.Чогсомжавтай 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдөр бичгээр байгуулсан 2018/08 тоот Хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлгэрсайханы Чогсомжавыг тус газрын Залуучуудын хөгжлийн төвийн Сургалт хариуцсан ажилтны албан тушаалд 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2. Д.Чогсомжавын сарын үндсэн цалинг TY-6-1 шатлал, зэрэглэл, ангилалд хамруулан 496912 /Дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун арван хоёр/ төгрөгөөр тогтоон цалинжуулахыг нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэн, эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг Д.Чогсомжавд үүрэг болгосугай.

4. Тус газрын Залуучуудын хөгжлийн төвийн Сургалт хариуцсан ажилтан Д.Чогсомжавд хөдөлмөрийн гэрээ, алжлын байрны тодорхойлолт, ажилд томилсон тухай тушаал тус бүрийн нэг хувийг гардуулж өгөхийг Захиргаа, хүний нөөц, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Ц.Энхбилгүүн/-д даалгасугай.

ДАРГА 
Ц. ГАНЗОРИГ

12 009

Tushaal-2018 docx